



## УЛААНБААТАР ЛИФТ НӨҮГ

Огноо. 2025.02.28

№ 20/Г

Улаанбаатар хот

### ЛИФТНИЙ СОЛИХ ШААРДЛАГАТАЙ ЭД АНГИ, СЭЛБЭГ МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 3/510 дугаартай албан хүсэлтийн дагуу тус дүүргийн 1 дүгээр хороо 26 дугаар байрны БНХАУ-н "Aerospace jinyang elevator" үйлдвэрийн 800кг даацтай 14 зогсоолтой 1,75м/с хурдтай 1ш хүн зөөврийн лифтний техникийн байдалд ЗТБХБ сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийн дагуу "Улаанбаатар лифт" НӨҮГ-ын механик инженер Б.Намуундөл, механик Л.Ангараг нар тус СӨХ-ны гүйцэтгэх захирал болон лифтчинг байлцуулан үзлэг, шалгалт хийлээ.


#### Шалгалтаар:

1. 26 дугаар байрны 1ш лифт дараах сэлбэг солих шаардлагатай. Тус лифт нь хэвийн ажиллаж байгаа боловч үндсэн инвертер гэмтэлтэй тул байнга алдаа зааж зогсдог бөгөөд тус лифтний үйлдвэр хаагдсан тул сэлбэг хэрэгсэл олдохгүй байдаг.

№	Сэлбэгийн нэр	Тоо хэмжээ	Тайлбар
1	Үндсэн инвертер гэмтэлтэй	1 ш	Шинээр солих
2	Үндсэн плат	1ш	Шинээр солих
3	Үндсэн ган татлага элэгдсэн	---	Шинээр солих
4	Гадна дуудлагын плат	---	Шинээр солих
5	Ажлын хөлс		


1. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын хүн зөөврийн лифтний сэлбэгүүд нь Олон улсын 180 14001, Европын 2014/33/EU, EN 81-20:2014 стандартын шаардлага хангасан байх ёстой.
2. Лифтний сэлбэг материалын угсралтын ажлыг гүйцэтгэхдээ ЗТБХБ сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийг баримтална.
3. Лифтний хонгилын хэсгийн барилгын үндсэн хийц эдлэлд өөрчлөлт оруулах, хучилтын хавтанд нэмэлт ачаалал өгөх, төхөөрөмж угсрах зорилгоор эвдэж гэмтээхийг хориглоно.
4. Уг лифтний нийлүүлэгч нь сэлбэг материалуудын угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.
5. Сэлбэг хэрэгслийг солихдоо хэмжилт хийх, тулгаж нягтлах шаардлагатай.

Гүйцэтгэгч байгууллага "Улаанбаатар лифт" НӨҮГ-ыг төлөөлж

Хянасан: Ерөнхий инженер  М.Энхбат

/тамга/

Гүйцэтгэсэн: Механик инженер  Б.Намуундөл

Механик  Л.Ангараг

